



СУМЫН ЗАСАГ ДАРГА Л.ГАНАА
2026 оны 03 дугаар сарын 30

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

УДИРДАМЖ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 18

Хориулт

“Өрхийн айлчлал” зохион байгуулах тухай

2026 оны 03 дугаар сарын 30

Хориулт

Нэг. Зорилго : Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай жигд хүргэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, удирдлагуудад уламжилах, мэдээ судалгаа авах, цаг үеийн болон сум орон нутгийн ажлын талаар мэдээлэл өгөх, иргэдтэй санал солилцох, сум орон нутгийн цаашид хийх цаг үеийн ажлаар танилцуулга хийх.

Хоёр. Хугацаа: 2026 оны 04 дүгээр сарын 01-04-ний өдрүүдэд.

Гурав. Хамрах хүрээ: Сумын 1, 2, 3, 4, 5, 6 дугаар багийн бүх айл өрх, иргэд
Дөрөв. Хийгдэх ажил:

1. Хаваржилтын байдалтай танилцаж, цаг үеийн ажлаар мэдээлэл солилцох (бэлчээр дэх малын идэш өвс ургамал хир байгаа, цаг агаарын байдал, хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан гал түймрийн аюул, малын болон орон байрны хулгай зэрэг эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сэрэмжлүүлэг өгөх).
2. Мал төллөлт, төл бойжилт, малын зүй бусын хорогдлын мэдээ авах.
3. Бүх төрлийн татварын ногдлыг танилцуулах, төсөвт төвлөрүүлэх талаар мэдээлэл өгөх.
4. Сайн дурын даатгалд хамрагдаж гэрээ байгуулсан иргэдэд мэдээлэл хүргэж, шимтгэлийг даруй төлүүлэх.
5. Малыг гоц халдварт болон халдварт өвчний талаар мэдээлэл өгч, урьдчилан сэргийлэх талаар танилцуулах.
6. Инженерийн хийцтэй худгуудын гэрээний хэрэгжилттэй танилцаж, нөхцөл байдлын тодруулга авах.

642633007

7. Иргэдээс шагналын судалгаа авах.
8. Иргэний үнэмлэх шинээр авах, сунгалт хийлгэх иргэдэд мэдээлэл хүргэх.
9. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2027 онд хийгдэх ажлын санал авах.
10. Автотехникийн үзлэг тооллогын зар хүргэх.

Тав. Багууд, айл өрхүүдэд ажиллах бүрэлдэхүүн:

Луугар 1 дүгээр багт Л.Ганзориг (Хөдөө аж ахуйн тасгийн дарга), Р.Ганцэцэг (Луугар 1 дүгээр багийн Засаг дарга), Б.Ариунзаяа (Багийн хүний эмч)

Гурван гол 2 дугаар багт Б.Бурмаа (Тамгын газрын дарга), Б.Нарангэрэл (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч), Ц.Буяннэмэх (Гурван гол 2 дугаар багийн Засаг дарга), Х.Баасансүрэн (Багийн хүний эмч)

Алтай 3 дугаар багт Т.Өнөржаргал (Нийгмийн даатгалын байцаагч), Г.Түмэндэмбэрэл (Санхүү албаны дарга), Д.Өлзийсайхан (Алтай 3 дугаар багийн Засаг дарга), М.Сангидулам (Багийн хүний эмч)

Цэлгэр 4 дүгээр багт А.Цолмон (Нийгмийн бодлогын мэргэжилтэн), Д.Ганболд (Цэлгэр 4 дүгээр багийн Засаг дарга), Г.Тогтох (Багийн хүний эмч), М.Билгүүнсаран (Цэцэрлэгийн хувилбарт сургалтын багш)

Буянт 5 дугаар багт Л.Ганаа (Сумын Засаг дарга), Г.Эрдэнэтөр (Мал амнэлгийн тасгийн тархвар зүйч), П.Батсайхан (Буянт 5 дугаар багийн Засаг дарга), Ц.Гансүх (Багийн хүний эмч)

Хориулт 6 дугаар багт З.Нанжидмаа (Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн), Ч.Насанжаргал (Хориулт 6 дугаар багийн Засаг дарга)

Зургаа. Ажил хариуцсан албан тушаалтнууд өөрсдийн явсан чиглэл, багт ажилласан тухай илтгэх хуудас, тайлан бичиж, зургаар баталгаажуулан, архивын баримт болгон танилцуулах.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
ОРЛОГЧ ДАРГА *Stando* Д.ГАНБОЛД







